

**ЁС ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР
ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

/Байгаль орчны газар/

2025.12.15

Орхон аймаг

Байгууллагын төрийн захиргааны 11 албан хаагч, төрийн үйлчилгээний 5 ажилтан нийт 16 албан хаагч, ажилтан ёс зүйн хэм хэмжээг байгууллагын хэмжээнд дагаж мөрдөж соёл, дэг журам, дүрэм, зааврыг чанд баримтлан Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, ёс зүйн дүрэм, стандартыг сурталчилж, сахин мөрдөх нөхцөлийг бүрдүүлж ажиллалаа. 2025 оны жилийн эцсийн байдлаар тус байгууллагад ёс зүйн болон захиргааны зөрчил дутагдал гаргасан албан хаагч байхгүй болно.

Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хороо, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл хамтран зохион байгуулсан “Бүсчилсэн хөгжил-төрийн албаны манлайлал” сэдэвт хойд бүсийн зөвлөгөөний Ёс зүйн дэд хороодыг чадавхижуулах салбар сургалтад хамрагдлаа.

Байгууллагын ёс зүйн дэд хороо, Орхон аймгийн Насан туршийн боловсролын төвтэй хамтран Байгууллагын хөгжил-багийн ажиллагаа хөтөлбөрийн хүрээнд байгууллагын соёл, үнэт зүйл, байгууллагын хөгжилд хувь хүний хандлага хэрхэн нөлөөлхийг таниулах зорилгоор “Байгууллага дахь хувь хүний хандлага”, “Байгууллага дахь зөрчлийн сэтгэл зүй” сэдэвт 2 удаагийн сургалтыг нийт албан хаагчдад зохион байгуулж ажиллалаа.

Байгууллагын албан хаагчдаас Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, тогтмоомжийн мэдлэг шалгах, түвшин тогтоох тестийг боловсруулан шалгалтын ажлыг зохион байгуулж ажиллалаа. Үүнтэй холбоотойгоор Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөртэй нийцүүлэн Байгууллагын ёс зүйн дэд хорооны 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг үйл ажиллагааны чиглэлээр 8 арга хэмжээ, Сургалт, нөлөөллийн чиглэлээр 4 арга хэмжээг төлөвлөн батлуулж Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хорооны цахим системд байршуулж ажиллалаа. Төлөвлөгөөний хэрэгжилт 2025 оны жилийн эцсийн байдлаар 90%-тай байна.

Байгууллагын хамт олны үнэлгээний дүнгээр хандлага, ёс зүйгээр хамгийн өндөр үнэлгээ авсан Архив, бичиг хэгийн ажилтанг шагнаж, урамшууллаа.

Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах” журмын дагуу Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ёс зүйн, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнан ажиллаж байна.

Байгууллагын албан хаагчдын дунд талархлын хайрцагийг 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн 1 сарын хуганцаанд ажиллуулж, ирсэн талархлуудыг албан хаагчдад хүргэх ажлыг элхион байгууллаа.

Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу 2024 оны Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах 5 албан хаагчийн мэдээллийг аймгийн эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсний дагуу Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс зохион байгуулсан 2025 оны ХАСХОМ бүрдүүлэлтийн үйл ажиллагааны талаар цахим сургалтад хамрууллаа.

Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор Байгаль орчны газрын веб **boajg.or.gov.mn** сайт болон Орхон аймгийн Байгаль орчны газрын фэйсбүүк пэйж хуудсаар авлигатай тэмцэх газраас бэлтгэн гаргасан инфографик, нийтлэл, зурагт хуудас мэдээллийг 7 удаа нийтлэж, өдөр тутмын болон цаг үеийн талаарх 112 мэдээллийг бэлтгэж, 23496 иргэдийг мэдээ, мэдээллээр хангаж ажиллалаа.

ТАЙЛАН ГАРГАСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН

МЭРГЭЖИЛТЭН

Г.ЗОЛБОО

ХЯНАСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН

ДАРГА

С.ЖАРГАЛСАЙХАН

